




БАЯНХОНГОР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2024 VI



<https://bayankhongor.nso.mn/>



Баянхонгор аймаг
2024 он


I Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II Дараах тэмдэглэгээг ашиглав.

- ... мэдээлэл байхгүй
- 0.0 маш бага тоо
- - гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл

III Хэмжих нэгжийн тэмдэглэгээ

- мянга =1000
- сая =10
- тэрбум =10
- их наяд =10¹²
- % хувь
- мм миллиметр
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- м² метр квадрат
- дм² дециметр квадрат
- км² километр квадрат
- м³ метр куб
- га гектар
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- Вт ватт
- кВт цкиловатт цаг
- калкалори ккалкилокалори
- Гкал гигакалори(=10⁹ калори)
- мкг/м³ микрограмм метр куб
-  Үүнээс гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

Агуулга

ХҮНАМ.....	4
ХӨДӨЛМӨР, БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД.....	6
НИЙГМИЙН ХАЛАМЖ.....	9
ЭРҮҮЛ МЭНД.....	14
БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК.....	17
ГЭМТ ХЭРЭГ.....	19
.....	23
МӨНГӨ, ЗЭЭЛ.....	23
ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ.....	27
ХӨДӨӨ АЖ АХУЙ.....	30
АЖ ҮЙЛДВЭР.....	34



ХҮН АМ

2024 оны 6 дугаар сарын байдлаар



Амаржсан эх

714



-11.7%



Төрсөн хүүхэд


718




-12.3%




Ердийн цэвэр өсөлт



Төрөлт



Нас баралт







Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 11.7 хувиар буурчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2024 оны эхний 7 сард 714 эх амаржиж, 718 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос төрсөн хүүхэд 101 (14.1%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт өмнөх оноос 1.1 нэгжээр буурсан байна.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 6 сард



ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 6 сард



2024 оны эхний 6 сард нас баралт 214 болж, өмнөх оноос 13 (5.7%)-аар буурч. 1000 хүнд ногдох нас баралт 2.4, ердийн цэвэр өсөлт 5.7 байна. 1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.2 нэгжээр буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр

Эх үүсвэр:

Аймгийн Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 6 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх


Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403




ХӨДӨЛМӨР, БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД
2024 оны 6 дугаар сарын байдлаар

Ажлын
Хайгууль



АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, боловсролын түвшингээр





2024 оны 6 сарын байдлаар аймгийн бүртгэлтэй ажилгүй иргэд 125 болж өмнөх сараас 9.6 хувиар буурчээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-44 насныхан 64.8 хувь буюу 81 иргэн, 45 дээш насныхан 35.2 хувь буюу 44 иргэн. Боловсролын түвшинээр нь харвал боловсролгүй 3, бага боловсролтой 13, суурь боловсролтой 59, бүрэн дунд боловсролтой 36, техникийн болон мэргэжлийн боловсролтой 3, тусгай мэргэжлийн боловсролтой 2, дипломын дээд боловсролтой 2, бакалаврын боловсролтой 7 иргэн байна.

Байнгын шинэ ажлын байранд 54 иргэний 44.4 хувь нь эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй 1 иргэн байна. Улсын төсвийн байгууллагад 30, орон нутгийн төсвийн байгууллагад 2, хувийн хэвшилд 22 ажлын байр шинээр гарсан байна.

2024 оны 06 сарын байдлаар 438 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд 262 хүнийг ажлын байранд зуучилж ажилтай болгосон байна. Ажилд орсон иргэдийн 43.9 хувь нь эмэгтэйчүүд, насны ангиллаар авч үзвэл: 66.8 хувийг 15-44 насныхан эзэлж байна.

ХҮСНЭГТ-1 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН АНГИЛЛААР

Ажлын байрны захиалга	2024 I-VI
Нийт	438
Менежер	13
Мэргэжилтэн	37
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	20
Контор, үйлчилгээний ажилтан	17
Худалдаа, үйлчилгээний ажилтан	39
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан	38
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил	6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	30
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	2
Энгийн ажил, мэргэжил салбарт	236

ХҮСНЭГТ-2 АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭДИЙН АЖЛЫН БАЙРНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, САЛБАРЫН АНГИЛЛААР

Ажилд зуучилсан иргэд	2024 I-VI
Нийт	262
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	65
Уул уурхай олборлолт	16
Боловсруулах үйлдвэрт	22
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарт	31
Барилга	2
Бөөний болон жижиглэн худалдаа машин мотоциклийн засвар үйлчилгээ	12
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	92
Боловсролын салбарт	13
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагааны чиглэлээр	5

Ойлголт, тодорхойлолт

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.

Хөдөлмөрийн насны хүн ам: 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403




НИЙГМИЙН ХАЛАМЖ

2024 оны эхний 6 дугаар сарын байдлаар


НИЙГЭМ



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 32,628.4 сая төгрөг улсын төсөв



НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 59.6 сая төгрөг орон нутгийн төсөв





Нийгмийн халамжийн сангаас 6 сард 5840.8 сая төгрөгийг олгожээ.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээгээр 2024 оны эхний 6 сарын байдлаар 69281 иргэнд 32688.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, урамшуулал, үйлчилгээнд олгожээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдсан иргэдийн тоо 1513 (-2.1%)-аар буурсан, олгосон тэтгэвэр, тэтгэмж 4251.8 (15%) сая төгрөгөөр өссөн байна.


ЗУРАГ 3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		<u>2024 I-VI</u>	Олгосон тэтгэвэр тэтгэмж		<u>2024 I-VI</u>
	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI
	тоо		хувь	сая төгрөг		хувь
Дүн	70638	69125	-2.1	28376.6	32628.4	15.0
Халамжийн тэтгэвэр	1856	1905	2.6	3058.7	3884.5	27.0
Халамжийн тэтгэмж	1939	2064	6.4	960.9	3275.7	240.9
Амьжиргаа дэмжих мөнгөн тусламж	1869	2006	7.3	568.4	832	46.4
Жирэмсэн эхийн тэтгэмжид	1337	1232	-7.9	153.9	144.1	-6.4
Алдарт эхийн одонгийн тусламж	8358	8447	1.1	1061.4	1058.1	-0.3
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	2	4	100.0	0.2	1.2	5 ¹
Насны хишиг	4063	4528	11.4	662.6	694.3	4.8
Цалинтай ээж хөтөлбөрийн хүрээнд	4796	4286	-10.6	1195.8	1111.6	-7.0
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөрийн хүрээнд	265	281	6.0	275	350	27.3
Ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	12	7	-41.7	24	21	-12.5
Хүүхдийн мөнгөн тэтгэмжид	36632	34784	-5.0	19695.5	20545.5	4.3
Хүнс тэжээлийн дэмжлэг тусламж үзүүлэх үйлчилгээ	5969	5229	-12.4	447.9	385.5	-13.9
Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа нэг удаагийн хөнгөлөлт, тусламж	3205	3881	21.1	181.6	236	30.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгогдож байгаа тусламж, хөнгөлөлт	188	324	72.3	72.5	69.9	-3.6
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум хорооны нийгмийн ажилтанд олгох урамшуулал	147	147	0.0	18.2	19	4.4


¹ дахин

Орон нутгийн төсвөөс амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 23 иргэнд 27.6, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 133 иргэнд 32.1 сая төгрөг тус тус олгосон байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад иргэдийн тоо 79 (33.6%)-аар буурсан, олгосон тэтгэмж 15.3 (34.4 %) сая төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 3. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ



ЗУРАГ 4. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРЛАГА сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн халамж Эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг

Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг

Байнгын асаргаа шаардлагатай иргэн бусдын туслалцаагүйгээр өдөр тутмын үйлдлээ бие даан гүйцэтгэх чадваргүй, эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүнийг

Бүтэн өнчин хүүхэд эцэг, эх нь тогтоогдоогүй, эсхүл эцэг, эх нь хоёул нас барсан, сураггүй алга болсон, эрх зүйн чадамжгүй, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, түүнчлэн эцэг тодорхойгүйн улмаас эхтэйгээ амьдарч байгаад эх нь нас барсан, гэр бүл салсны улмаас асрамждаа авсан эх /эцэг/ нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийг

Өрх толгойлсон эх /эцэг/ нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсхүл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг.

Эх үүсвэр:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15



2024 оны эхний 6 дугаар сарын байдлаар 12936 өндөр настанд 44741.9 сая төгрөгийн тэтгэвэр олгожээ.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээгээр нийгмийн даатгалын сангийн орлого 2024 оны эхний 6 сарын байдлаар 61119.8 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, төрлөөр, жил бүрийн эхний 6 дугаар сарын байдлаар

Үзүүлэлт	2023 I-VI	2024 I-VI	2024 I-VI 2023 I-VI
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	49099.6	61119.8	124.5
Тэтгэврийн даатгалын сан	43231.3	54188.1	125.3
Тэтгэмжийн даатгалын сан	1752.9	2128.4	121.4
Эрүүл мэндийн даатгалын сан	3106.1	4037.3	130.0
ҮОМШӨ-ний даатгалын сан	501.7	278	55.4
Ажилгүйдлийн даатгалын сан	507.6	488	96.1

2024 оны эхний 6 сарын байдлаар 14317 иргэнд 54402.0 сая төгрөгийг олгожээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад олгосон тэтгэвэр, тэтгэмж 13136.0 (24.2%) сая төгрөгөөр өссөн байна.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ
54,402.0 сая төгрөг**

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН САН 51712.5

- Өндөр насны тэтгэвэр 44741.9
- Тахир дутуугийн тэтгэвэр 4502.7
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 1538.4
- Цэргийн тэтгэвэр 929.5

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН 2194.1

- Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 8.8
- Жирэмсэн болон амаржсаны тэтгэмж 1829.3
- Оршуулгын тэтгэмжид 356.0

ҮОМШӨ-ний ДААТГАЛЫН САН 133.0

- Тахир дутуугийн тэтгэвэр 53.8
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 79.2

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛЫН САН

- Ажилгүйдлийн тэтгэмж 495.4

Тэтгэврийн даатгалын сан өмнө оны мөн үес 12411.8 (24%) , тэтгэмжийн даатгалын сан 729.4 (33.2%), ҮОМШӨ-ний даатгалын сан 25.1 (18.8%), сая төгрөгөөр тус тус өссөн. Ажилгүйдлийн даатгалын сан 5.2 (1.1%) сая төгрөгөөр буурсан үзүүлэлтэй байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж: Хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.

Эх үүсвэр:

Нийгмийн даатгалын хэлтэс
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15


Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат
Утас: 70442081, 70442403



ЭРҮҮЛ МЭНД

2024 оны эхний 6 дугаар сарын байдлаар

ЭМНЭЛЭГТ ХЭВТЭН
ЭМЧЛҮҮЛЭГЧИД



2023 I-VI 12814

2024 I-VI 13023

1.6%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2023 I-VI

600

2024 I-VI

823

27.1%



1 хүртэлх насны хүүхдийн
эндэгдэл

2023 I-IV

8

2024 I-IV

8



1-5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдэл

2023 I-IV

11

2024 I-IV

10



Эхний 6 дугаар сарын байдлаар 164.9 мянган хүнд үзлэг хийгдсэнээс 27.5 хувийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулжээ.

Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн төвийн нийт үзлэгийн 49.3 хувийг Нэгдсэн эмнэлэг, 19.2 хувийг өрхийн ЭМТ, 29.4 хувийг хувийн ортой эмнэлгүүд, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгийн 44.5 хувийг эх эмчийн үзлэг, 37.1 хувийг багийн эмчийн, 11.4 хувийг эх баригчийн, 7.0 хувийг сумын бага эмчийн үзлэг эзэлж байна.

Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын хувь эхний 6 сарын байдлаар 99.3 хувьтай.

Аймгийн хэмжээнд эхний 6 сарын байдлаар 714 эх төрж, өнгөрсөн оны мөн үеэс 95 төрөлтөөр буурсан. Нийт төрсөн эхийн 96.1 хувь нь аймгийн Нэгдсэн эмнэлэгт, 3.9 хувь нь сумын эмнэлэгт төрсөн. Нас баралтын 214 тохиолдол бүртгэгдсэний 61.7 хувь нь эрэгтэйчүүд эзэлж байна. Нийт нас баралтын 23.8 хувь нь эмнэлэгт нас барснаас 37.3 хувь нь хоног болоогүй нас барсан нь өнгөрсөн оны мөн үеэс (хоноггүй 2023 онд 30.9 хувь) нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд хорт хавдрын 44, осол гэмтлийн 31 нас баралт бүртгэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад осол гэмтлийн шалтгаант нас баралт нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


Эхний 6 сард аймгийн хэмжээнд нийт 823 халдварт өвчин бүртгэгдэж 10.000 хүн амд 93.2 хувь байгааг 2023 оны мөн үетэй (25.6) харьцуулахад нэмэгдсэн үзүүлэлттэй байна. БЗДХ-ын тохиолдлын тоо урьд оны мөн үеэс өсч, нийт халдварт өвчний 34.0 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 5. ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, БҮТЦЭЭР



Өмнөх оны мөн үеэс БЗДХ-ын тохиолдлын тоо нэмэгдэж нийт халдварт өвчний 34.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өвчлөгчдийн 37.5 хувийг эрэгтэйчүүд, 62.5 хувийг эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 6. ХАЛДВАРТ ӨВЧИН ТӨРӨЛ, хувиар



Өмнөх онд гарч байсан бруцеллёз, арьсны мөөгөнцөр, халдварт гепатит, сальмонелёзын халдвар, нярайн бактерт үжил, улаан-эсэргэнэ зэрэг халдварт өвчнүүд гараагүй, бүслүүр үлд 4 тохиолдол шинээр гарчээ.

Тайлант хугацаанд 7093 түргэн тусламжийн дуудлага бүртгэгдсэний 23.6 хувийг алсын, 3.54 хувийг осол гэмтлийн дуудлага эзэлж байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад түргэн тусламжийн нийт дуудлагын тоо буурсан, нийт дуудлагад эзлэх алсын дуудлагын хувь нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрөлт: Хүн төрөлхтний дунд явагдаж буй нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд эмэгтэйчүүдийн амьд төрүүлсэн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.

Төрөлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох амьд төрсөн хүүхдийн тоог илэрхийлнэ.

Нас баралт: Хүн төрөлхтний дунд гарч буй нөхөн үжихүйн үзэгдлийн нэг. Хүн амын амьжиргааны түвшин, амьдралын хэв маяг, эрүүл ахуйн нөхцөл, өвчлөл нь нас баралтын түвшинд нөлөө үзүүлдэг учир энэ үзүүлэлтийг нас баралтын шалтгаанаар нь тодорхойлж болно.

Нас баралтын ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох нас баралтын тоог илэрхийлнэ.

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.

Эх үүсвэр:

Эрүүл мэндийн газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403



БОЛОВСРОЛЫН СТАТИСТИК


2023/2024 оны хичээлийн жилд

МОНГОЛЫН
УЛАМ
МОНГОЛЫН
УЛАМ


Ерөнхий боловсролын сургууль



Сургуулийн өмнөх боловсролын байгууллага



Ерөнхий боловсролын сургуульд ажиллагсдын тоо



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын ажиллагсдын тоо






2023-2024 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 12 дугаар ангийг 860 суралцагч төгссөн байна

Ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд 19082 суралцагчид суралцаж 5 дугаар ангийн 2054 суралцагч, 9 дүгээр ангийн 1648 суралцагч, 12 дугаар ангийн 860 суралцагч төгссөн байна. Харин 1-4 дүгээр ангийг 7512 суралцагч, 6-8 дугаар ангийг 5268 суралцагч, 10, 11 дүгээр ангийг 2205 суралцагч амжилттай дэвшин суралцсан байна. Энэ хичээлийн жилд үндсэн багшаар 997 багш ажилласан бөгөөд өмнөх оноос 17.7 хувиар нэмэгдсэн байна.


СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ

2023-2024 оны хичээлийн жилд 236 бүлэгт 7551 хүүхэд хүмүүжиж, таван настай 1932 хүүхэд төгсөж, бага, дунд, ахлах бүлгийг 5619 хүүхэд амжилттай төгссөн байна. Нийт 914 ажилчин боловсролын үйлчилгээ үзүүлж, ажилдагсдын 51.9 хувийг багш нар эзэлж байна.

ЗУРАГ 7. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД ӨДРӨӨР СУРАЛЦАГЧИД, жил бүрийн хичээлийн жилд



ЗУРАГ 8. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН хичээлийн



Ойлголт, тодорхойлолт

Суралцагч: Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчдын тоо, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхдийн тоо байна.

Эх үүсвэр:

Аймгийн Боловсрол Шинжлэх Ухааны газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 6 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат
Утас: 70442081, 70442403



ГЭМТ ХЭРЭГ

2024 оны 6 дугаар сарын байдлаар

ᠭᠡᠮᠡᠲᠦ
ᠬᠡᠷᠭᠢᠨ

БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ

2023 I-VI
VI

189

2024 I-VI

368

94.7% ↑

БҮРТГЭГДСЭН ЗӨРЧИЛ



2023 I-VI

17094

2024 I-

17298

1.2% ↑

ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС:



Хохирсон хүн
330



Гэмтсэн хүн
117



Нас барсан
13

БҮРТГЭГДСЭН ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ:



Торгууль шийтгэл
Ноогдуулсан 16660



Баривчлагдсан
267

Торгож, тээврийн
хэрэгсэл жолоодох
эрх хасах 166



Шийдвэрлээгүй
үлдсэн 60



ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОЛ 1365.0 сая төгрөг



Гэмт хэргийн улмаас 1365.0 сая төгрөгийн хохирол учирснаас 439.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, төлүүлэлт 32.2 хувьтай байна.


Аймгийн Цагдаагийн газрын мэдээгээр эхний хагас жилд иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2373 дуудлага, мэдээлэл хүлээн авч шалгасан нь өмнөх оны мөн үеийнхээс 130 нэгжээр буюу 5.8 хувиар өссөн. Үүнээс 810 буюу 34.1 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 1563 буюу 65.9 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 90 буюу 11.1 хувийг 5 хоногт, 630 буюу 77.7 хувийг 6-19 хоногт, зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн 1502 буюу 96.1 хувийг 5 хоногт шалгаж шийдвэрлэжээ. Хүлээн авч шалгасан гомдол, мэдээллээс гэмт хэргийн шинжтэй 78 буюу 9.6 хувийг, зөрчлийн шинжтэй 35 буюу 2.2 хувийг шийдвэрлээгүй, хуулийн хугацаанд шалгагдаж байна.

ЗУРАГ 9. ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ



ЗУРАГ 10. ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ



Аймгийн хэмжээнд тайлант хугацаанд 368 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 179 буюу 94.7 хувиар өссөн. Энэ хугацаанд хэрэг бүртгэлтийн 263 хэрэг бүртгэгдсэнээс 65 хэргийн холбогдогчийг яллагдагчаар татаж ял сонгосон. Нийт гэмт хэргийн илрүүлэлт 24.7 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 21 пунктээр буурсан. Бүртгэгдсэн гэмт хэргийн 243 буюу 66 хувь нь Баянхонгор суманд, 125 буюу 33.9 хувь нь бусад сумдад үйлдэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5 НИЙТ БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ /ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН БҮЛГЭЭР/ ҮОӨ

Хэргийн бүлэг	2023.VI	2024.VI	<u>2023.VI</u> <u>2024.VI</u>
Бүртгэгдсэн гэмт хэрэг	189	368	179
Хүнийг алах	2	1	-1
Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	0	5	5
Хүний эрүүл мэндийн халдашгүй байлын эсрэг	74	100	26
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	9	14	5
Үүнээс: Хүчиндэх	8	11	3
Хулгайлах	32	41	9
Мал хулгайлах	18	13	-5
Дээрэм	1	6	5
Залилах	20	93	73
ХАБЭГХ	10	30	20
Үүнээс: 27.10.5 /СТХЖ/	0	20	20
Хүрээлэн буй орчны эсрэг	7	5	-2
Бусад	16	60	44
Хэргийн илрүүлэлт	45.7%	24.7%	21%


Бүртгэгдсэн гэмт хэргийн 307 буюу 83.4 хувь нь хөнгөн ангиллын, 61 буюу 16.5 хувь нь хүнд ангиллын гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэрэг үйлдсэн байдлаар авч үзвэл цахим орчинд

үйлдэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 68.6 дахин өссөн байна.

ЗУРАГ 11. ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДСЭН БАЙДАЛ тоогоор




ЗУРАГ 12 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ үйлдэгдсэн газар, цаг хугацаа



Нийт бүртгэгдсэн 368 гэмт хэргээс 85 буюу 23.1 хувь нь гэр орон сууцанд, 41 буюу 11.5 хувь нь гудамж талбайд, 44 буюу 11.9 хувь нь олон нийтийн газар, 9 буюу 2.4 хувь нь төрийн байгууллагад, 30 буюу 8.1 хувь нь авто замд, 16 буюу 4.3 хувь нь аж ахуйн нэгжид, 141 буюу 38.3 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 340 иргэн хохирч, үүнээс 117 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 33 нэгжээр буюу 39.2 хувиар, 13 хүн нас барсан нь 7 нэгжээр буюу 1.1 дахин тус тус өссөн. Гэмт хэргийн улмаас 1365.0 сая төгрөгийн хохирол учирснаас 439.6 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 32.2 хувьтай байна.

ЗУРАГ 13 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН хүн, хохирол, мянган төгрөг



ЗӨРЧЛИЙН МЭДЭЭ

Аймгийн хэмжээнд эхний хагас жилд 17298 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 204 буюу 1.2 хувиар өсөж, үүнээс 17240 зөрчил буюу 99.5 хувийг нь шийдвэрлэсэн байна. Нийт бүртгэгдсэн зөрчлийн 13766 буюу 79.8 хувийг замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих, 170 буюу 0.9 хувийг танхайрах, 110 буюу 0.6 хувийг бусдын биед халдах, 150 буюу 0.8 хувийг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, 3044 буюу 17.6 хувийг бусад зөрчил эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. ЗӨРЧИЛ ҮЙЛДЭГДСЭН ОНЦЛОГ

Зөрчил үйлдэгдсэн байдал	2023.VI	2024.VI	/Өсөлт,бууралт/	Хувь
Согтуугаар	888	766	-122	-13.7
Хүүхэд оролцсон	17	29	12	70.5

Эмэгтэй хүн оролцсон	155	178	23	14.8
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас	130	150	20	15.3
Олон нийтийн газар	45	69	24	53.3
Гэр орон сууцанд	311	357	46	14.7
Гудамж талбайд	945	730	-215	-22.7

Энэ хугацаанд 367 иргэн эрүүлжүүлэгдэн, албадан саатуулагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 124 нэгжээр буюу 51 хувиар өссөн эрүүлжүүлэгдэн албадан саатуулагдсан иргэдийн 22 буюу 6 хувь нь эмэгтэй хүн байна.

Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Аймгийн Цагдаагийн газар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403




МӨНГӨ, ЗЭЭЛ

2024 оны 6 дугаар сарын байдлаар

МОНГОЛ
БАНК
ОЙРГО



Нийгээлдэгчийн
Тоо



2023 I-VI **52388**

2024 I-VI **55805**



Зээл
2024 I-VI

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл

422.9
тэрбумтөгрөг



5.5
тэрбумтөгрөг

Анхаарал хандуулах
зээлийн өрийн үлдэгдэл



6.8
тэрбумтөгрөг

Чанаргүй
зээл



Нийхэдгэм



190.5
тэрбумтөгрөг

Хугацрагай




144.5
тэрбумтөгрөг

Хугацраггүй



45.9
тэрбумтөгрөг



Салбарнагжийн
Тоо **240**

АТМ-ийн тоо **45**

Хадгаламжийн данс
эзэмшигчдийн тоо

68583

Харилцах данс
эзэмшигчдийн тоо

151380

Төлбөрийн карт
эзэмшигчдийн тоо


69547



Хугацаа хэтэрсэн зээл 6 дугаар сарын байдлаар 6.831,5 сая төгрөг болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2 хувийг эзэлж байна.

Монгол Банкны аймаг дахь салбараас ирүүлсэн мэдээгээр 2024 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл 422,972.4 сая төгрөг байгаагийн 5,510.0 сая төгрөг нь анхаарал хандуулах зээл /хугацаа хэтэрсэн/, 6,831.5 сая төгрөг нь чанаргүй зээл байна. Өмнөх оны мөн үеэс зээлийн өрийн үлдэгдэл 42.7 хувиар нэмэгдэж, хугацаа хэтэрсэн зээл 1.9 хувиар буурч, чанаргүй зээл 32.1 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

ЗУРАГ 13 НИЙТ ӨР, ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЭЛ ангилал



Хадгаламжийн үлдэгдэл 6 дугаар сарын 30 ний өдрөөр нийт 190,515.8 сая төгрөгт хүрсэн бөгөөд нийт хадгаламжийн 24.1 хувийг хугацаагүй хадгаламж, 75.8 хувийг хугацаатай хадгаламж эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс хадгаламжийн үлдэгдэл 42674.9 сая төгрөгөөр өсч хадгаламж эзэмшигчдийн тоо 3536 нэмэгджээ.

Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр:

Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403




Аймгийн төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өсчээ.

Татварын хэлтсийн мэдээгээр тайлант хугацаанд аймгийн хэмжээнд 19227.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж нийт орлогын төлөвлөгөө 19.7 хувиар давж биелсэн байна. Үүнээс аймгийн төвлөрсөн төсөвт 4430.7 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 2.8 хувиар тасарсан, сумдын төсөвт 14327.3 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 31.6 хувиар давж биелсэн байна.

ХҮСНЭГТ 7. ТАТВАРЫН ОРЛОГО БИЕЛЭЛТ өссөн дүнгээр сая төгрөг

Үзүүлэлт	2023 I-VI	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт	2024 I-VI 2024 I-VI
Нийт орлого	11330.2	16058.0	19227	119.7	169.7
Улсын төсвийн орлого	1747.8	2514.1	2235.7	88.9	127.9
Аймгийн төсвийн орлого	1394.3	1305.0	1452.6	111.3	104.2
Сумын төсвийн орлого	7169.8	10882.9	14327.4	131.7	199.8
Татварын бус орлого	1018.3	1355.9	1211.3	89.3	119.0

ЗУРАГ 14. ТӨСВИЙН ОРЛОГО БҮТЭЦ хувиар



Аймгийн төсөвт төвлөрөх орлогоос ААНОАТ40%, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 25-60 хувь давж биелсэн бол ус рашаан ашигласны төлбөр 70.4 хувиар тасарсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Орон нутгийн төсөв: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв юм.

Орон нутгийн төсвийн орлого: Татварын орлого, татварын бус орлого, хөрөнгийн орлогоос бүрдэнэ.

Татварын орлого: Орлогын албан татвар, өмчийн албан татвар, бусад татвар, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Түрээсийн орлого, хүүгийн орлого, торгуулийн орлого, нэр зааж ангилагдаагүй орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогоос бүрдэнэ.

Эх үүсвэр: Татварын хэлтэс

Мэдээлэл авах холбоос:
<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:
2024 оны 7 дугаар сарын 15




Дотоодын нийт бүтээгдэхүүн 786.8 тэр бум болж өмнөх оны оноос 45.3 хувиар өсчээ.

Аймгийн ДНБ (оны үнээр) 2023 онд 786.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 45.3 хувиар өсч, аймгийн ДНБ улсын дүнд 1.0 хувийг эзэлж байна. Аймгийн ДНБ-ийг томсгосон 3 салбар буюу хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбараар харьцуулан авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 389.5 тэрбум, үйлдвэрлэлийн салбар 110.8 тэрбум, үйлчилгээний салбар 287.2 тэрбум төгрөгөөр бүрдүүлжээ. Хөдөө аж ахуйн үйл ажиллагаа сэргэсэнтэй холбоотой өмнөх оноос хөдөө аж ахуйн салбар 32.3 хувиар, үйлчилгээний салбар 32.6 хувиар, үйлдвэрлэлийн салбар 29.1 хувиар нэмэгдсэн байна.


ХҮСНЭГТ 7. ДНБ, салбараар *- дахин их

Он	ДНБ	Дүн эзлэх тэрбум төгрөг			НӨ-ийн жилийн цэвэр өөрчлөлт хувь			
		Хөдөө	Үйлдвэр-	Үйлчил-	ДНБ	Хөдөө	Үйлдвэр-	Үйлчил-
2020	572.6	301.7	115.7	155.2	26.1	29.9	55.5	5.3
2021	350	130.9	46.2	172.9	-38.9	-56.6	-59.9	11.3
2022	541.3	263.6	74.2	203.5	54.6	101.3	60.6	17.6
2023*	786.8	389.5	110.2	287.2	45.3	47.7	48.5	41.1

ЗУРАГ 15. АЙМГИЙН ДНБ-ИЙ БҮТЭЦ, салбараар, дүнд эзлэх хувь



ЗУРАГ 16. НЭГ ХҮНД НОГДОХ ДНБ, сая төгрөг



Нэг хүнд ногдох ДНБ аймгийн дүнгээр 2023 онд 8.9 сая төгрөг болж өмнөх оны 48.3 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Ойлголт, тодорхойлолт:

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд тайлант хугацаанд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн шинээр бүтээсэн нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг дараах 3 аргаар тооцно.

Үйлдвэрлэлийн арга: Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг,

Эцсийн ашиглалтын арга: Эцсийн хэрэглээ, хөрөнгийн нийт хуримтлал, цэвэр экспортын (экспорт, импортын зөрүү) нийлбэрээр тооцохыг,

Орлогын арга: Ажиллагчдын цалин хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ, үйлдвэрлэл, импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг/холимог орлого зэрэг орлогын үзүүлэлтийн нийлбэрээр тооцохыг ойлгоно.


Эх үүсвэр: ҮСХ, бүс нутгийн ДНБ-ий гүйцэтгэл



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙНУЛСЫН ИНДЕКС, бүлгээр,
хувиар, 2024 оны 6 дугаар сард

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙНУЛСЫН ИНДЕКС





Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувиар өслөө.


Аймгийн хэмжээнд 2024 оны 06 дугаар сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны жилийн эцсээс 5.7 хувиар өссөн, өмнөх сартай харьцуулснаар 0.6 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 8. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

№	Барааны бүлгээр	2024.VI	2024.VI	2024.VI
		2023.VI	2023.XII	2024.V
	Ерөнхий индекс	105.6	105.7	99.4
1	Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	105.5	111.5	97.1
2	Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	100.3	98.4	100.2
3	Хувцас, бөс бараа, гутал	102.2	100.4	100.8
4	Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад	105.1	103.6	100.1
5	Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	101.1	99.1	100.2
6	Эм тариа эмнэлгийн үйлчилгээ	104	100.7	100.2
7	Тээвэр	99.4	98.3	100
8	Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	109.2	108	103.6
9	Амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	109.1	100.8	101.2
10	Боловсролын үйлчилгээ	110.6	100	100
11	Зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	118.9	118.9	102.7
12	Бусад бараа үйлчилгээ	120.1	116	100.5

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн өөрчлөлтийг 7 хоног бүр цуглуулж судалдаг өмнөх оны мөн үеэс үхрийн махны үнэ 7.1 хувиар, цагаан будааны үнэ 2.6 хувиар, элсэн чихрийн үнэ 20 хувиар өссөн, ямааны ястай мах 7.7 хувиар, дизелийн түлш 2.7 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

ХҮСНЭГТ 17. ГОЛ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ 7 ХОНОГИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2024 сараар, төгрөгөөр



ХҮСНЭГТ 9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, ХҮНСНИЙ ГОЛ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ҮНЭ, өмнөх оны мөн үеэс

Нэр төрөл	Хэмжих нэгж	2023.VI	2024.VI	2024.VI / 2023.VI
1-р зэргийн гурил	кг	2700	2700	100
Хонины мах	кг	14000	14000	100
Үхрийн цул мах	кг	14000	15000	107.1
Ямааны мах	кг	13000	12000	92.3

Элсэн чихэр	кг	4000	4800	120
Цагаан будаа	кг	3800	3900	102.6
Шингэн сүү	л	5000	5000	100
Бензин АН-92	л	2530	2530	100
Дизель түлш	л	3740	3640	97.3

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Эх үүсвэр:

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403




ХӨДӨӨ АЖ АХУЙ

МАЛ АЖ АХУЙ


2024 оны 6 дугаар сар

Мал төллөлт, 2024 оны 6 дугаар сард

ᠮᠠᠯ ᠲᠡᠯᠯᠡᠯᠲ



ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр



Аймгийн хэмжээнд 2024 оны 6 дугаар сарын байдлаар оны эхний хээлтэгчийн 56.1 хувь төллөжээ.

2024 оны 6 дугаар сарын мал төллөлт, төл бойжилтын мэдээгээр нийт 967.6 мянган толгой хээлтэгч төлөж өмнөх оноос 21.2 хувиар буурч, төл бойжилт 90 хувьтай. Оны эхний төллөөгүй хээлтэгчийг төрлөөр нь авч үзвэл гүү 37.2 (62.1), үнээ 46.4 (49.1), ингэ 12.2 (67.3) эм ямаа 204.3 (38.8), эм хонь 456.7 (44.5) мянган толгой эзэлж

байна.

ХҮСНЭГТ 9. МАЛ ТӨЛЛӨЛТ, төрлөөр, жил эхний 6 дугаар сар

Төрөл	Оны эхний хээлтэгч		Төллөсөн хээлтэгч			Төлөлтийн хувь	
	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2024 I-VI 2023 I-VI	2023 I-VI	2024 I-VI
	мянган толгой					хувь	
Бүгд	1533.9	1724.8	1229.1	967.7	78.7	80.1	56.1
Адуу	56.9	60.0	38.5	22.7	59.0	67.7	37.8
Үхэр	91.0	94.6	68.6	48.1	70.2	75.3	50.9
Тэмээ	17.5	18.2	6.7	5.9	88.4	38.5	32.7
Хонь	473.6	526.8	398.1	322.4	81.0	84.1	61.2
Ямаа	894.9	1025.2	717.2	568.5	79.3	80.1	55.5

Эхний 6 дугаар сард 871.0 мянган төл бойжиж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад бойжсон төл 26.5 хувиар буурчээ.

ХҮСНЭГТ 10. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, жил эхний 6 дугаар сар

Төрөл	Гарсан төл		Бойжсон төл			Хорогдсон төл	
	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2024 I-VI 2023 I-VI	2023 I-VI	2024 I-VI
	мянган толгойгоор					хувь	
Бүгд	1229.6	967.7	1186.1	871.1	73.4	96.5	90.0
Унага	38.5	22.7	36.8	21.4	58.3	95.4	94.3
Тугал	68.6	48.1	66.7	45.0	67.5	97.2	93.6
Ботго	6.7	5.9	6.6	5.9	88.9	98.7	99.2
Хурга	398.2	322.4	384.6	281.6	73.2	96.6	87.3
Ишиг	717.6	568.5	691.4	517.2	74.8	96.4	91.0


Том малын зүй бус хорогдол 2024 оны эхний 6 дугаар сард аймгийн хэмжээнд 266338 болж, өмнөх оны мөн үеэс 237329 (8.9 дахин) толгойгоор өссөн байна. Оны эхний малд нийт хорогдсон малын эзлэх хувь 6.5 болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.5 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 11. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр, жил эхний 6 дугаар сар

Малын төрөл	Хорогдсон мал		Оны эхний малд эзлэх хувь		Өвчнөөр хорогдсон мал	
	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2023 I-VI	2024 I-VI
	толгойгоор		хувь		толгойгоор	
Бүгд	29009	266338	0.8	6.5	3	485
Адуу	1721	11178	3.8	6.3	0	0
Үхэр	5148	33518	3.2	14.1	2	0
Тэмээ	37	384	0.0	0.8	1	0
Хонь	9184	82005	0.8	6.7	0	134
Ямаа	12919	139253	0.6	5.8	0	351

Эхний хагас жилийн байдлаар ямааны хорогдол нийт хорогдлын 52.3 хувийг эзэлж, өмнөх оноос өвчөөр хорогдсон мал 2 төрөл дээр шинээр нэмэгдсэн байна.

ЗУРАГ 18. ТОМ МАЛЫН ХОРОГДОЛ ТӨРӨЛД эзлэх хувиар/нийт хорогдолд өвчнөөр хорогдсон малын эзлэх хувь



Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Тооцох аргачлал: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

Мэдээлэл авах холбоос: <https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх
Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат
Утас: 70442081, 70442403



Үр тариа 3.4 мянган га-д тариалалт хийсэн байна.

Аймгийн хэмжээнд 2024 оны 6 дугаар сарын байдлаар төмс 131.7 га,

хүнсний ногоо 127.5 га, үр тариа 3.9 мянган га, тэжээлийн ургамал 282.3 га-д тариалжээ. Тариалалтын биелэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөл тус бүрээр нь авч үзвэл үр тарианы тариалалт 164.3 хувь, хүнсний ногоо 85.6 хувь, төмс 79.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Тариалсан талбайн нийт хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.9 хувиар өссөн байна.

ХҮСНЭГТ 12. ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га

Талбай	2021 I-VI	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI	2024 I-VI 2023 I-VI
Нийт тариалсан талбай	575.3	685.1	539.8	526.7	-13.1
Үр тариа	5.42	7.8	2.1	3.45	1.4
Төмс	202.7	196.3	165.5	131.8	-33.7
Хүнсний ногоо	130.2	128.4	127.6	109.2	-18.4
Тэжээлийн ургамал	236.9	352.7	244.6	282.3	37.7


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэжээлийн ургамал 33.7 мянган га-аар, үр тариа 1.4 га-аар тус тус өсч, төмс 33.7 га-аар, хүнсний ногоо 18.4 га-аар буурчээ.




АЖ ҮЙЛДВЭР

**АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ
ҮЙЛДВЭРЛЭЛ, 2024 оны 6 дугаар сард**



Уул уурхай, олборлолт тэрбум төгрөг




Боловсруулах үйлдвэрлэл тэрбум төгрөг



Цахилгаан, хий, уур, агааржуулалт тэрбум төгрөг



Ус хангамж; сувагжилтын систем, хог хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа тэрбум төгрөг



56 хувиар буурсан байна.


2024 оны эхний 6 дугаар сарын урьдчилсан гүйцэтгэлээр 28839.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5336.1 сая төгрөг буюу 15.6 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 13. НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сая төгрөг

Үзүүлэлт	2021 I-VI	2022 I-VI	2023 I-VI	2024 I-VI	<u>2024* I-VI</u> 2023 I-VI
Нийт	30745.6	36368.4	34175.9	28839.8	-5336.2
Уул уурхай, олборлолт	24654.8	30679.2	25796.0	19861.3	-5934.7
Боловсруулах үйлдвэрлэл	1145.2	1034.5	1179.1	957.2	-221.9
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3825.3	3436.6	5930.2	6109.2	178.9
Ус хангамж; сувагжилтын систем, хог Хаягдал зайлуулах болон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	1120.2	1218.1	1270.6	1912.0	641.5

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлт өмнөх оны мөн үеэс 56.0 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт 1695.3 сая төгрөгөөр буурсан нь голлох нөлөөг үзүүлжээ.

ЗУРАГ 19. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг



ХҮСНЭГТ 14. НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар, сая төгрөг

Салбар	2021 I-VI	2022 I-VI	2023 I-VI	2024* I-VI
Дэд салбарын нийт дүн	30745.6	36368.4	34175.9	28842.8
Чулуун, хүрэн нүүрс олборлолт	386.1	490.2	886.6	917.4
Металлын хүдэр олборлолт	24268.7	30188.9	24909.4	18943.9
Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл	794.1	643.8	1136.5	746.7
Ээрэх, нэхэх, даавуун материал бэлтгэх үйлдвэрлэл	79.6	120.2	6.9	13.2
Хувцас үйлдвэрлэл	165.3	178.5	18.8	44.8
Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	8.5	0.0	5.0	108.7
Хэвлэх, дуу бичлэгийг хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа	0.0	1.2	0.0	0.0
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	96.0	70.2	12.0	15.0
Тавилга үйлдвэрлэл	1.7	0.0	0.0	0.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3825.3	3436.6	5930.2	6109.2
Ус хуримтлуулах, ариутгах, түгээх үйл ажиллагаа	755.6	856.2	901.8	1214.7
Хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, зайлуулах; дахин ашиглах	364.6	361.9	368.8	700.4

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: Хувиараа үйлдвэрлэл эрхлэгч иргэн болон ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

Мэдээлэл авах холбоос:

<https://bayankhongor.nso.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2024 оны 7 дугаар сарын 15

Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх

Статистикийн хэлтсийн дарга Г.Ганчимэг, Ахлах мэргэжилтэн Ч.Эрдэнэбат

Утас: 70442081, 70442403